



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/76/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер:
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор:
Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Төлбөрийн акт	14
4.2 Албан шаардлага	14
4.3 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 84

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭРДЭНЭЦЭЦЭГ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,276,615.63</u>	<u>100,752,937.19</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	1,648,941.70
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	1,648,941.70
3121	Төгрөг	00.00	1,648,941.70
31211	Төрийн сангийн харилцах	00.00	9,075.70
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	1,639,866.00
33	АВЛАГА	832,715.63	66,990,515.49
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	270,065.58	00.00
335	Бусад авлага	562,650.05	66,990,515.49
3351	Байгууллагаас авах авлага	562,650.05	66,990,515.49
35	БАРАА МАТЕРИАЛ	26,443,900.00	32,113,480.00
354	Хангамжийн материал	26,443,900.00	32,113,480.00
35420	Аж ахуйн материал	26,443,900.00	32,113,480.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>534,163,624.30</u>	<u>594,022,653.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	534,163,624.30	594,022,653.58
392	Биет хөрөнгө	524,867,624.30	584,726,653.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	481,346,815.54	481,346,815.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	-49,714,593.33	-69,600,077.49
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,180,000.00	221,880,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-114,910,222.56	-116,763,333.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	205,342,478.93	211,869,186.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-163,512,858.64	-178,646,743.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,965,400.00	50,965,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,326,958.92	-39,077,693.71
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,186,600.00	34,186,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,689,036.72	-11,433,500.00
393	Биет бус хөрөнгө	9,296,000.00	9,296,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,296,000.00	9,296,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>561,440,239.93</u>	<u>694,775,590.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>223,890.00</u>	<u>35,443,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	223,890.00	35,443,000.00
413	Өглөг	223,890.00	35,443,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	22,000,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	21,000.00	3,827,500.00
4136	Бусад өглөг	202,890.00	9,615,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	202,890.00	8,615,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>561,216,349.93</u>	<u>659,332,590.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	561,216,349.93	659,332,590.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	474,399,517.94	474,399,517.94
51101	Өмч: - төрийн	474,399,517.94	474,399,517.94

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	-71,834,454.88	26,281,785.96
51210	Өмнөх үеийн үр дүн	-71,834,454.88	-71,834,454.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	98,116,240.84
51600	Нөөцийн сан	158,651,286.87	158,651,286.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	561,440,239.93	694,775,590.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	544,321,968.00	1,050,322,170.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	123,804,320.00	224,859,707.56
120	Нийтлэг татварын бус орлого	90,724,740.00	223,859,707.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,724,740.00	223,859,707.56
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	90,724,740.00	223,859,707.56
122	Тусламжийн орлого	33,079,580.00	1,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	33,079,580.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,417,248.00	417,694,563.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	401,100,400.00	407,767,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,417,248.00	359,642,943.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,108,348.00	358,966,743.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	308,900.00	676,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	39,592,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	39,592,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	18,459,320.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	18,459,320.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	539,272,532.83	952,205,929.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	539,272,532.83	952,205,929.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,427,462.82	919,137,145.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,561,900.52	418,821,371.39
210101	Үндсэн цалин	211,043,422.52	311,079,797.09
210102	Нэмэгдэл	52,586,672.10	83,141,369.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,237,000.00
210104	Урамшуулал	24,931,805.90	23,363,205.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,799,999.47	42,662,600.00
210201	Тэтгэврийн даатгал	26,599,999.48	30,023,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,800,000.00	3,160,282.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,240,000.00	2,528,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	560,000.00	632,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,599,999.99	6,319,018.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,914,253.00	34,592,299.47
210301	Гэрэл, цахилгаан	2,825,292.00	3,401,524.47
210302	Түлш, халаалт	31,088,961.00	31,190,775.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,219,700.00	26,805,062.00
210401	Бичиг хэрэг	3,400,000.00	3,540,400.00
210402	Тээвэр, шатахуун	24,139,700.00	19,651,662.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,960,000.00	2,893,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	720,000.00

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	44,849,899.00	108,795,098.05
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,249,899.00	94,577,673.05
210502	Хоол, хүнс	9,600,000.00	14,217,425.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,395,047.00	5,274,616.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,063,882.00	954,600.00
210604	Урсгал засвар	4,331,165.00	4,320,016.00
2107	Томилолт, зочны зардал	1,084,000.00	1,030,000.00
210702	Дотоод албан томилолт	1,084,000.00	1,030,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,750,000.00	211,128,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,750,000.00	211,128,820.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,852,663.83	70,027,278.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,320,255.00	4,359,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,532,408.83	65,667,678.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	845,070.01	33,068,784.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	659,090.00	32,791,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	659,090.00	32,791,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	185,980.01	277,084.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	185,980.01	277,084.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,049,435.17	98,116,240.84
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,049,435.17	98,116,240.84

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	474,399,517.94	158,651,286.87	-71,834,454.88	561,216,349.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	474,399,517.94	158,651,286.87	-71,834,454.88	561,216,349.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	98,116,240.84	98,116,240.84
D09	2021 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	474,399,517.94	158,651,286.87	26,281,785.96	659,332,590.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	453,597,228.00	761,386,363.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,079,580.00	1,000,000.00
122	Тусламжийн орлого	33,079,580.00	1,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	33,079,580.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,517,648.00	760,386,363.00

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	401,100,400.00	407,767,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,417,248.00	294,566,843.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,108,348.00	293,890,643.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	308,900.00	676,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	39,592,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	39,592,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	18,459,320.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	18,459,320.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	453,597,228.00	759,737,421.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,597,228.00	759,737,421.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	451,011,247.99	726,668,636.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,561,900.52	398,465,721.30
210101	Үндсэн цалин	211,043,422.52	290,717,615.00
210102	Нэмэгдэл	52,586,672.10	83,147,901.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,237,000.00
210104	Урамшуулал	24,931,805.90	23,363,205.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,799,999.47	42,662,600.00
210201	Тэтгэврийн даатгал	26,599,999.48	30,023,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,800,000.00	3,160,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,240,000.00	2,528,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	560,000.00	632,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,599,999.99	6,319,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,914,253.00	34,592,299.47
210301	Гэрэл, цахилгаан	2,825,292.00	3,401,524.47
210302	Түлш, халаалт	31,088,961.00	31,190,775.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,219,700.00	26,672,822.00
210401	Бичиг хэрэг	3,400,000.00	3,400,000.00
210402	Тээвэр, шатахуун	24,139,700.00	19,659,822.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,960,000.00	2,893,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	720,000.00
2105	Нормативт зардал	44,664,948.00	38,674,295.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,104,948.00	30,999,600.00
210502	Хоол, хүнс	9,600,000.00	7,674,695.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	960,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,395,047.00	5,307,516.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,063,882.00	954,600.00
210604	Урсгал засвар	4,331,165.00	4,352,916.00
2107	Томилолт, зочны зардал	1,084,000.00	1,030,000.00
210702	Дотоод албан томилолт	1,084,000.00	1,030,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,000,000.00	174,763,383.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	174,763,383.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,371,400.00	4,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,371,400.00	4,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,585,980.01	33,068,784.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,400,000.00	32,791,700.00

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	32,791,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	185,980.01	277,084.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	185,980.01	277,084.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	1,648,941.70
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	1,648,941.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,648,941.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	481,723,000.00	465,533,359.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	481,723,000.00	465,533,359.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	479,723,000.00	463,541,659.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	318,598,500.00	307,666,799.30
210101	Үндсэн цалин	204,809,000.00	199,918,693.00
210102	Нэмэгдэл	78,873,200.00	83,147,901.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,796,000.00	1,237,000.00
210104	Урамшуулал	29,120,300.00	23,363,205.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,662,600.00	42,662,600.00
210201	Тэтгэврийн даатгал	30,023,000.00	30,023,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,160,300.00	3,160,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,528,300.00	2,528,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	632,000.00	632,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,319,000.00	6,319,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,592,300.00	34,592,299.47
210301	Гэрэл, цахилгаан	3,407,300.00	3,401,524.47
210302	Түлш, халаалт	31,185,000.00	31,190,775.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,080,000.00	26,617,562.00
210401	Бичиг хэрэг	3,400,000.00	3,400,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,000,000.00	19,604,562.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,960,000.00	2,893,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	720,000.00
2105	Нормативт зардал	39,759,600.00	38,674,295.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,999,600.00	30,999,600.00
210502	Хоол, хүнс	7,800,000.00	7,674,695.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	960,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	5,307,516.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	954,600.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,352,916.00
2107	Томилот, зочны зардал	1,030,000.00	1,030,000.00
210702	Дотоод албан томилот	1,030,000.00	1,030,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000.00	2,490,588.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	2,490,588.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4500000.00	4500000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	4,500,000.00

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2000000.00	1991700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,991,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,991,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	481,723,000.00	465,542,435.47
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	407,767,900.00	407,490,815.47
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	407,767,900.00	407,490,815.47
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,592,300.00	39,592,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	39,592,300.00	39,592,300.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	18,459,320.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,362,800.00	18,459,320.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	9,075.70

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	293,926,977.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	293,926,977.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	263,126,977.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,798,922.0
210101	Үндсэн цалин	90,798,922.0
2104	Хангамж, бараа материалын зардал	55,260.0
210402	Тээвэр, шатахуун	55,260.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	172,272,795.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,272,795.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,800,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,800,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,800,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	295,566,843.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	295,566,843.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	293,890,643.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	676,200.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	1,639,866.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,639,866.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөртэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Алтансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төв нь “Үйлчлэх хүрээний хүн ам нийгмийн эрүүл мэндийн болон анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, шударга, жигд, хүртээмжтэй, чанартай үзүүлж эмч эмнэлгийн ажилтны ёс зүй, хариуцлагыг дээшлүүлж, баг бүрдүүлэн ажиллах.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 539.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133,335.4 мянган төгрөгөөр буюу 23.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,648.9	1,648.9
Авлага	832.7	66,990.5	66,157.8
Бараа материал	26,443.9	32,113.5	5,669.6
Үндсэн хөрөнгө	534,163.6	594,022.7	59,859.0
Нийт хөрөнгө	561,440.2	694,775.6	133,335.4
Богино хугацаат өр төлбөр	223.9	35,443.0	35,219.1
Засгийн газрын хувь оролцоо	561,216.3	659,332.6	98,116.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	561,440.2	694,775.6	133,335.4

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 594,022.7 мянган төгрөг болж, 59,859.0 мянган төгрөгөөр, авлагын дансны үлдэгдэл 66,990.5 мянган төгрөг болж, 66,157.8 мянган төгрөгөөр, богино хугацаат өр төлбөрийн данс 35,443.0 мянган төгрөг болж, 35,219.1 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Авлагын дансны үлдэгдэл өсөхөд Ковидын халдвар авсан иргэдэд хэвтэн эмчилгээ хийсэнтэй холбоотой зардлыг ЭМД-ийн сангаас авах авлагаар тайлагнасан нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өсөхөд 125,526.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан нь нөлөөлжээ. Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл өсөхөд ковидын халдвар авсан иргэдийн хэвтэн эмчилгээнд илүү эмч, эмнэлгийн ажилтнуудын илүү цагаар ажилласантай холбоотой цалингийн өглөг 22,000.0 мянган төгрөг, ковидын халдвараас хамгаалах хэрэглэлийн худалдан авалттай холбоотой өглөг 8,615.5 мянган төгрөг, ковидын вакцины тарилгатай холбоотой 3,827.5 мянган төгрөгийн өглөг нөлөөлсөн байна.

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 506,000.2 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилтийн орлого, урсгал

үйл ажиллагааны санхүүжилт байна. Тодруулбал үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 133,135.0 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 340,225.7 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 46,259.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 412,933.4 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж гэсэн зардлууд байна. Тодруулбал өмнөх оноос цалингийн зардал 130,259.5 мянган төгрөгөөр, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал 59,327.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 208,378.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 584,816.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг үүсвэрийг 584,816.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 103,093.3 мянган төгрөгөөр бууруулж 481,723.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тухайн байгууллагын 2021 онд 31 арга хэмжээ бүхий “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” 80.4 хувьтай хэрэгжсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 481,723.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 409,427.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 39,592.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 32,702.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 407,767.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 39,592.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 18,459.3 мянган төгрөг, нийт 465,819.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 465,533.3 мянган төгрөгийг зарцуулж, 277.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, харилцах дансанд 9.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 465,819.5 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих зардлын гүйцэтгэл 18,459.3 мянган төгрөг гарч, батлагдсан дүнгээс 15,903.5 мянган төгрөгөөр бага санхүүжилт авсантай холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ковид цар тахалтай холбоотойгоор 1,000.0 мянган төгрөгийн хандив, дээд шатны төсөв захирагчаас 293,890.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 676.2 мянган төгрөг, нийт 295,566.8 мянган төгрөгийн санхүүжилт

авч, 293,926.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 1,639.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төв нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.5-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 2 хөтөлбөр, 5 арга хэмжээний хэрэгжилт 80.4 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж, зарцуулсан төсвийн гүйцэтгэл 96.6 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд санхүүжилтийг мэдээлээгүй, жилийн дүн нь 5 сая төгрөгөөс дээш бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй, 88 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”

- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан бөгөөд 724.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,960.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн байна. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 1,914.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөртэй холбоотой 3 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

1. Тайлант оны эцэст 1,914.4 мянган төгрөгийн НДШ-ийн авлагын үлдэгдэлтэй буюу төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, 7.7, 45.2 дахь заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон.

4.2. Албан шаардлага

1. Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд санхүүжилтийг мэдээлээгүй, жилийн дүн нь 5 сая төгрөгөөс дээш бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй, 88 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна. Иймд энэхүү зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 139 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Богино хугацаат өр төлбөртэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд татварын өглөг, авлага тусгагдаагүй байхад татварын байгууллагын тодорхойлолтоор суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 1,847.1 мянган төгрөгийн илүү, цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар 9,936.5 мянган төгрөгийн илүү, зам ашигласны төлбөр 12.0 мянган төгрөгийн дутуу төлөлттэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагын тодорхойлолт дахь татварын илүү, дутуу төлөлтийг татварын байгууллагатай тооцоо нийлж, санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнах.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Нэг бүр нь 58.5 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг утлагын аппаратыг 2018 онд орлого авахдаа тоо хэмжээ, үнийн дүнг зөрүүлж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Утлагын аппаратыг тоо хэмжээ, нэгжийн үнийн дүнг зөрүүлж бүртгэсэн зөрчлийг арилгаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											

Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Сүхбаатар сумын эрүүл мэндийн төв	4	1.9	0	0	1	1.9	0	0	3	0
Дүн		4	1.9	0	0	1	1.9	0	0	3	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Сүхбаатар сумын эрүүл мэндийн төв	1	0	0	0	0	0	1	0	0	0
Дүн		1	0	0	0	0	0	1	0	0	0
Нийт дүн		5	1.9	0	0	1	1.9	1	0	3	0